



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД
НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ НЬ

2024.00.00

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч: Оршин суугаа хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрын дугаар, утасны дугаар

Хариуцагч: Оршин суугаа хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрын дугаар, утасны дугаар

Нэхэмжлэлийн шаардлага: Хүүхдийн эцэг, тэтгэлэг тогтоолгох

Миний бие А.Баттай 2010 онд танилцаж, 2011 оноос хамтран амьдарсан. Бидний хүү Г.Мөнх 2013 оны 07 сарын 10-ны өдөр төрсөн. Бид гэрлэлтээ бүртгүүлээгүй, мөн тухайн үед хүүгийн эцэг А.Бат нь хөдөө орон нутагт хамгаалалтын албанд ажиллаж байсан тул хүүгээ өөрөөрөө овоглож төрсний гэрчилгээ авсан.

Бид зан харьцаа, гэр бүлээс гадуурх харилцаанаас болж 2014 оны 12 сараас тусдаа амьдарч байгаа бөгөөд цаашид хамтран амьдрах боломжгүй болсон. А.Бат нь хүүгээ миний хүүхэд биш гэдэг шалтгаанаар огт хайхардаггүй. Хүү Г.Мөнх нь энэ жил 1 дүгээр ангид суралцаж байгаа бөгөөд хичээлийн хэрэгсэл, хувцас, бусад зардлуудыг миний бие ганцаар хариуцахад хүндрэлтэй байна.

Иймд А.Батыг 2013 оны 07 сарын 10-ны өдөр төрсөн хүү Г.Мөнхийн эцгээр тогтоож, тэтгэлэг гаргуулж өгнө үү.

ЖИЧ: НЭХЭМЖЛЭЛИЙГ 2 ХУВЬ ӨГНӨ.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалт:

1. Миний иргэний үнэмлэхийн хуулбар /нотариатчаар гэрчлүүлсэн/
2. Хүү Г.Д-ийн төрсний гэрчилгээний хуулбар /нотариатчаар гэрчлүүлсэн/
3. Хүүхэд эрүүл бойжиж байгаа тухай Өрхийн эрүүл мэндийн төвийн Эмнэлэгийн магадлагаа /Эх хувь/
4. Хүүхэд сургуульд суралцдаг тухай тодорхойлолт /Эх хувь/
5. Миний оршин суугаа хорооны Засаг даргын тодорхойлолт /Эх хувь/
6. Улсын тэмдэгтийн хурааж төлсөн баримт Жич: Тэтгэлэг тогтоолгох шаардлагад улсын тэмдэгтийн хураамж 70200 төгрөг төлнө. Хүүхдийн эцэг тогтоолгох шаардлагад тэмдэгтийн хураамж 70.200 төгрөгийг нэмж төлнө.

Улсын тэмдэгтийн хураамжийг Татварын ерөнхий газрын itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэж, дурын банкны салбарт тушаах эсхүл шүүхийн байранд байршуулсан Gegece системийн өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр банкны карт ашиглан төлөх боломжтой.

Нэхэмжлэл гаргасан:

Нэр ... гарын үсэг ... гарын үсгийн тайлал